



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/171

Хэрлэн сум

Цаг агаарт зориудаар нөлөөлөх
экспедицийн үйл ажиллагаанд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой хээрийн түймрийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх, газар тариалан, бэлчээрийн ургамлын ургалтанд шаардлагатай хөрсний чийг болон гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хуурайшилт, цөлжилтийг сааруулах зорилгоор аймгийн хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн үйл ажиллагааны зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Экспедицийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж тухай бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-д үүрэг болгосугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Санхүүжилт олгох сар		Нийт үнэ (төгрөг)
		2023.03	2023.06	
1	Шатахуун	3,000,000	900,000	3,900,000
2	Томилолт	3,000,000	1,600,000	4,600,000
3	Автомашины засвар үйлчилгээ, бусад	1,500,000		1,500,000
Дүн (төгрөг)		7,500,000	2,500,000	10,000,000